



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 777

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2,054,300.00 (хоёр сая тавин дөрвөн мянга гурван зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Акталж, данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

1320174

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 14 дугаар сарын 28-ны өдрийн
АТ дугаар тогтоолын хавсралт

**"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" төрийн өмчид хувьцаат
компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн
жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
			(төгрөг)
1	Авто ачигч, 50-65 ЭТ, тусгай	1986/1987	2,054,300.00
НИЙТ ДҮН			2,054,300.00
			(хоёр сая тавин дөрвөн мянга гурван зуун)